



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 сарын 04 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 18<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

**“18<sup>1</sup> дүгээр зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

18<sup>1</sup>.1. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээдэд гэрчилгээ олгоход 100 000-250 000 төгрөгийн хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР